

ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

## **АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Үндэсний аудитын газар  
2018 он

## АГУУЛГА

Агуулга .....	1
Товчилсон үгийн жагсаалт .....	2
Аудитын нэр .....	3
Аудитын код .....	3
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх .....	3
Аудитын зорилт .....	3
Аудитын хамрах хүрээ .....	3
Үндсэн мэдээлэл .....	4
Эрсдэлийн үнэлгээ .....	4
Аудитын арга зүй .....	5
Аудит хийхэд ашиглах шалгуур үзүүлэлт:.....	5
Аудитын гүйцэтгэх хугацаа .....	5
Аудит хийх багийн бүрэлдэхүүн .....	5
Аудитад шаардагдах хөрөнгө, нөөц .....	5-6
Хавсралт №1 Эрсдэлийн үнэлгээ .....	7
Хавсралт №2 Асуудлын шинжилгээ .....	8
Хавсралт №3 Аудитын арга зүй .....	9-12
Хавсралт №4 Аудитын үр өгөөжийн төлөвлөлт .....	13
Хавсралт №5 Аудитын хөтөлбөр .....	14-16

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
НА	Нийцлийн аудит
НАГ	Нийцлийн аудитын газар
ТББ	Төрийн бус байгууллага
ТЭЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар



## АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Аудитын нэр: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт
2. Аудитын код: УАГ-НАГ-2018/01/-НА
3. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалт, Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.3 дахь хэсгийг тус тус үндэслэн УИХ-ын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2017 оны 06 дугаар тогтоол, Үндэсний аудитын газрын 2018 онд хийх аудитын төлөвлөгөөний дагуу гүйцэтгэнэ.

### 4. Аудитын зорилт:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, аудитын дүнг УИХ-д танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ.

Дээрх зорилтын хүрээнд дараах чиглэлийн дагуу аудитыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1<sup>1</sup>, 3.1.2<sup>2</sup>-т заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн эсэх;
- Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3<sup>3</sup>, 3.1.4<sup>4</sup>, 3.1.5<sup>5</sup>-д заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг бүрэн мэдээлсэн эсэх;
- Шилэн дансны тухай хуульд заасан холбогдох байгууллага, албан тушаалтан хяналтыг хэрэгжүүлж, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг биелүүлсэн эсэх.

### 5. Аудитын хамрах хүрээ:

Аудитаар Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-3.1.2 дахь хэсэгт заасан хуулийн этгээд, төрийн байгууллагыг тус хуулийн 8 дугаар зүйлийн 8.2<sup>6</sup>-д заасны дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчдаас хэрэгжүүлж буй дотоод хяналтын дүн мэдээнд үндэслэн түүвэрлэн шалгана.

Мөн хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-3.1.5-д заасан байгууллага, албан тушаалтныг бүрэн хамруулах бөгөөд 3 дугаар зүйлийн 3.1.4-3.1.5-д заасан байгууллага, албан тушаалтны шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулсан

<sup>1</sup> Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд

<sup>2</sup> төрийн өмчит үйлдвэрийн газрууд

<sup>3</sup> Хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компаниуд

<sup>4</sup> Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллагууд

<sup>5</sup> Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгчид

<sup>6</sup> Энэ хуулийн 3.1.1-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ.

мэдээлэлд “Нээлттэй нийгэм форум” ТББ-тай байгуулсан гэрээний дагуу судалгаа, дүн шинжилгээ хийлгэн дүнг аудитын тайланд нэгтгэнэ.

Аудитаар 2017 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2018 оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацааны Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгана.

#### **6. Үндсэн мэдээлэл:**

Улс, орон нутгийн төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх зорилго бүхий Шилэн дансны тухай хууль 2015 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээд Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 7 төрлийн мэдээлэл, 3.1.2-т заасан төрийн өмчит үйлдвэрийн газар 7 төрлийн мэдээлэл, 3.1.3-т заасан хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани 3 төрлийн мэдээлэл тус бүр оруулахаар хуульчилсан байна.

Төрийн аудитын байгууллагаас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2015, 2016 онуудад жилд тус бүр 2 удаа аудит хийж, хуулийн хэрэгжилтийг тайлагнасан бөгөөд 2016 оны 4 дүгээр улиралд хийсэн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 31 ТЕЗ, тэдгээрийн харьяа 1009 байгууллага дунджаар 97.4 хувь, аймаг, нийслэлийн 22 ТЕЗ, тэдгээрийн харьяа 3854 байгууллага дунджаар 87.5 хувьтай хэрэгжүүлсэн нь 2016 оны 1 дүгээр улиралд гүйцэтгэсэн аудитын дүнгээс улсын төсвийн 31 ТЕЗ тэдгээрийн харьяа байгууллагуудын хэрэгжилт 1.4 хувиар өссөн байхад, аймаг, нийслэлийн 22 ТЕЗ тэдгээрийн харьяа байгууллагуудын хуулийн хэрэгжилт 2.6 хувиар буурчээ.

Дээрх 4 удаагийн аудитын явцад илэрсэн зөрчилд тухай бүр залруулга хийлгэж ажилласнаас гадна нийт 369.8 сая төгрөгийн зөрчил илрүүлж давхардсан тоогоор 1174 байгууллагад 1087 хариуцлага тооцуулах хугацаатай албан шаардлага хүргүүлж ажилласан байна.

Энэ удаагийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахдаа иргэд, олон нийтийн оролцоог хангаж, аудитыг ил тод гүйцэтгэх зорилгоор “Нээлттэй нийгэм форум” ТББ-ыг шинжээчээр оролцуулж, хамтран ажиллахаар гэрээ байгуулсан бөгөөд тус байгууллагаас судалгаа, дүн шинжилгээ хийж ирүүлсэн дүгнэлт, тайланг МУЕА-ын дэргэдэх “Аудитын иргэний танхим”-аар хэлэлцүүлж, аудитын тайланд нэгтгэнэ.

Мөн аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газруудад төлөвлөгөөг хүргүүлж нэгдсэн удирдамжаар гүйцэтгэнэ.

#### **7. Эрсдэлийн үнэлгээ:**

Төлөвлөлтийн үе шатны явцад судалсан баримт материал, хамрах хүрээ, нөхцөл байдалд хийсэн урьдчилсан дүн шинжилгээнд үндэслэн ерөнхий эрсдэлийг “ДУНД” гэж үнэлсэн. /Хавсралт №1-д үзүүлэв/

## 8. Арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100-400, 4000, 4100 дугаар стандартууд болон Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журмыг баримтлан хуулийг хэрэгжүүлэгч байгууллага, аж ахуйн нэгжийн мэдээллийн самбар болон цахим хуудаст байрлуулсан мэдээллийг дансны хуулгын дүн, анхан шатны баримт, журналтай тулгах, дүн шинжилгээ хийх, холбогдох албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага зохион байгуулах, иргэд, хэрэглэгчдээс судалгаа авах зэрэг аудитын арга зүйг ашиглаж, аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулна. /Асуудлын шинжилгээ, арга зүйн дэлгэрэнгүйг хавсралт 2, 3-д үзүүлэв/

## 9. Аудит ашиглах шалгуур үзүүлэлт:

Аудитын зорилттой холбоотой дараах хууль, дүрэм, журам, зааврыг шалгуур үзүүлэлт болгон ашиглана. Үүнд:

- Монгол Улсын 2017 оны Төсвийн тухай хууль;
- Монгол Улсын 2017 оны Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль;
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль;
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- Шилэн дансны тухай хууль;
- Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”;
- Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”
- Бусад холбогдох хууль, дүрэм, журам

## 10. Гүйцэтгэх хугацаа:

Аудитын төлөвлөлтийн үе шатны ажлыг 2018 оны 9 дүгээр сарын 10-ны өдрөөс, талбарын ажлыг 10 дугаар сарын 08-ны өдрөөс, тайлагналын үе шатны ажлыг 11 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн, тайланг 2018 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор үе шатны хяналтаар оруулж, МУЕА-ын тушаалаар баталгаажуулан УИХ-д хүргүүлнэ. /Нарийвчилсан цаглабар бүхий хөтөлбөрийг хавсралт 5-д үзүүлэв/

Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрууд тайланг 2018 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийцлийн аудитын газарт файлаар [otgonbayard@audit.gov.mn](mailto:otgonbayard@audit.gov.mn) хаягаар болон цаасан сууриар ирүүлнэ.

## 11. Багийн бүрэлдэхүүн:

Аудитыг УАГ-ын Нийцлийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор С.Энхбаатар хянан удирдаж, аудитын менежер Х.Болдбаатар аудитын стандарт, арга зүйн дагуу үе шатны хяналт тавьж, ахлах аудитор Д.Отгонбаяр, аудитор С.Сугармаа, Ц.Цэрэннамжил, Б.Уранчимэг нар болон Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрууд

хөтөлбөр, хуваарийн дагуу "Нээлттэй нийгэм форум" ТББ-ыг гэрээ, ажлын даалгаврын хүрээнд шинжээчээр оролцуулж гүйцэтгэнэ.

**12. Аудитад шаардагдах хөрөнгө, нөөц:**

**А. Боловсон хүчин:**

- ҮАГ-аас: 5 хүн 65 өдөр, нийт 325 хүн/өдөр
- Орон нутгаас: 44 хүн 65 өдөр, нийт 2860 хүн/өдөр

**Б. Санхүүгийн нөөц:**

- Цалин – 289,198.0 мянган төгрөг
- Томилолтын зардал – 1,210.0 мянган төгрөг

**В. Техник хэрэгсэл: Зөөврийн компьютер болон бусад тоног төхөөрөмж**

**Г. Бусад**

**ТАНИЛЦСАН:**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ОРЛОГЧ  
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

*[Signature]*  
С.ОЮУНБИЛЭГ

**ХЯНАСАН**

НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ  
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

*[Signature]*  
С.ЭНХБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР

*[Signature]*  
Х.БОЛДБААТАР

**БОЛОВСРУУЛСАН:**

АХЛАХ АУДИТОР

*[Signature]*  
Д.ОТГОНБАЯР

АУДИТОР

*[Signature]*  
Ц.ЦЭРЭННАМЖИЛ

*[Signature]*  
С.СУГАРМАА

*[Signature]*  
Б.УРАНЧИМЭГ

АУДИТЫН ЕРӨНХИЙ ЭРСДЭЛҮҮД БА ҮНЭЛГЭЭ

Д.д	Эрсдэл	Хавсралт №1		
		Магадлал	Үр дагавар	Үнэлгээ
1	Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-3.1.3-т заасан байгууллагууд бүрэн хамрагдаагүй байх	Бага	Их	Дунд
2	Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-3.1.5-т заасан байгууллагууд бүрэн хамрагдаагүй байх	Их	Их	Их
3	Байгууллагын шилэн дансны мэдээлэл байршуулах цахим хуудас хуульд заасан шаардлага хангаагүй байх	Дунд	Их	Дунд
4	Мэдээллийн самбар нь иргэдийн мэдээлэлтэй чөлөөтэй танилцах боломжийг хангаагүй байх, тавигдсан мэдээлэл эрх бүхий албан тушаалтан баталгаажуулаагүй байх	Дунд	Дунд	Дунд
5	Байгууллагууд шилэн дансны мэдээллийг өөрийн цахим хуудаст тогтоосон хугацаанд иж бүрэн, үнэн зөв байршуулаагүй байх	Дунд	Их	Дунд
6	Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг мөрдөөгүй байх	Дунд	Их	Дунд
7	Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуй нэгж байгууллагууд мэдээллээ байршуулаагүй байх	Их	Их	Их
8	Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч аж ахуйн нэгж, байгууллагууд мэдээллээ байршуулаагүй байх	Их	Их	Их
9	Нэгдсэн системд мэдээлэл оруулахад техник хэрэгсэл, сүлжээний хүчин чадал, интернетийн сүлжээ ашиглах боломж хангалтгүй байх	Бага	Дунд	Дунд
10	Шилэн дансны үйл ажиллагаанд хийх холбогдох хяналтыг хэрэгжүүлээгүй байх	Дунд	Дунд	Дунд
11	Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байх	Дунд	Их	Дунд

**Материаллаг байдал**

1	Шилэн дансны мэдээлэл байршуулах хуульд заасан шаардлагууд хангагдаагүй байх чанарын хүчин зүйл	Дунд	Их	Дунд
---	-------------------------------------------------------------------------------------------------	------	----	------

- Их гэж үнэлсэн "3"
- Дунд гэж үнэлсэн "8"

Ерөнхий эрсдэлийг "Дунд" гэж үнэлсэн болно.

Хянасан: НАГ-ын захирал бөгөөд тэргүүлэх аудитор

НАГ-ын аудитын менежер

Боловсруулсан: НАГ-ын ахлах аудитор

НАГ-ын аудитор



С.Энхбаатар




Х.Болдбаатар



Д.Отгонбаяр




С.Сугармаа



Ц.Цэрэннамжил

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт



Танилцсан: НАГ-ын захирал бөгөөд тэргүүлэх аудитор

Хянасан: НАГ-ын мөнөжөр

Боловсруулсан: НАГ-ын ахлах аудитор

Аудитор

С.Энхбаатар

Х.Болдбаатар

Д.Отгонбаяр

С.Сугармаа

Ц.Цэрэннажиг

## АУДИТЫН АРГА ЗҮЙ

Аудитын нэр: "ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙХ АУДИТ"

Аудитын код: УАГ-НАГ-2018/01/-НА

СУДАЛГААНЫ АСУУЛТ (Бид юу мэдэхийг хүсэж байна вэ?)	ШАЛГУУР (Бид ямар стандарттай харьцуулж байгаа вэ?)	ШААРДЛАГАТАЙ НОТЛОХ ЗҮЙЛ (Ямар нотлох зүйл асуултад хариулах вэ?)	НОТЛОХ ЗҮЙЛИЙН ЭХ СУРВАЛЖ (Бид нотлох зүйлийг хэнээс олж авах вэ?)	МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ АРГА ЗҮЙ (Бид нотлох зүйлийг хэрхэн олж авах вэ?)	МЭДЭЭЛЛИЙГ ШИНЖЛЭХ АРГА ЗҮЙ (Олж авсны дараа бид юу хийх вэ?)
<b>Үндсэн зорилт: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аудит хийх</b>					
<b>А. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн эсэх</b>					
А.1. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газрууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн эсэх	<ul style="list-style-type: none"> <li>- Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх заалт</li> <li>- Шилэн дансны тухай хуулийн 6, 7 дугаар зүйл</li> <li>- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 13 дугаар 13.1-13.3 дахь заалт, 15 дугаар зүйл</li> <li>- Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын 1 дүгээр зүйлийн 1.2 дахь заалт</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- ТАБ-ын Санхүүгийн аудитад хамрагдсан Шилэн дансны тухай хуулийн 3.1.1-3.1.2-т заасан хуулийн этгээдийн жагсаалт</li> <li>- Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст бүртгэгдсэн Шилэн дансны тухай хуулийн 3.1.1-3.1.2-т заасан хуулийн этгээдийн жагсаалт</li> <li>- Шилэн дансны тухай хуулийн 3.1.1-3.1.2-т заасан хуулийн этгээдийн Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулсан мэдээлэл</li> <li>- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн мэдээ, тайлан</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Аудитад хамрагдаж буй байгууллага</li> <li>- Шилэн дансны нэгдсэн цахим хуудас</li> <li>- Аудитад хамрагдаж байгууллагын цахим хуудас</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Холбогдох баримт материал, цахим хуудастай танилцах,</li> <li>- Шалгах хуудас ашиглах</li> <li>- Тайлбар, мэдээлэл гаргуулах</li> <li>- Ярилцлага хийх,</li> <li>- Аудитын бусад горим, арга зүй</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Баталгаажуулалт хийх</li> <li>- Батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон төлөвлөсөн горимын дагуу нотлох зүйлд үндэслэн санал, дүгнэлт боловсруулах</li> </ul>
А.2. Орон нутгийн төсөв, түүний төсвийн захирагчид шилэн дансны мэдээллийг байгууллагын мэдээллийн самбарт хуульд заасан шаардлагын дагуу бүрэн мэдээлсэн эсэх	<ul style="list-style-type: none"> <li>- Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь заалт</li> <li>- Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Байгууллагын мэдээллийн самбарт байршуулсан мэдээлэл</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Аудитад хамрагдаж буй байгууллага</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Байгууллагын мэдээллийн самбарт байршуулсан мэдээлэлтэй танилцаж, хянах</li> </ul>	

СУДАЛГААНЫ АСУУЛТ (Бид юу мэдэхийг хүсэж байна вэ?)	ШАЛГУУР (Бид ямар стандарттай харьцуулж байгаа вэ?)	ШААРДЛАГАТАЙ НОТЛОХ ЗҮЙЛ (Ямар нотлох зүйл асуултад хариулах вэ?)	НОТЛОХ ЗҮЙЛИЙН ЭХ СУРВАЛЖ (Бид нотлох зүйлийг хэнээс олж авах вэ?)	МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ АРГА ЗҮЙ (Бид нотлох зүйлийг хэрхэн олж авах вэ?)	МЭДЭЭЛЛИЙГ ШИНЖЛЭХ АРГА ЗҮЙ (Олж авсны дараа бид юу хийх вэ?)
А.3. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн эсэх	<ul style="list-style-type: none"> <li>- Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 6.5 дахь заалт</li> <li>- Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Сангийн яамны Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулсан мэдээлэл</li> <li>- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн мэдээ, тайлан</li> </ul>	Сангийн яам	<ul style="list-style-type: none"> <li>- Холбогдох баримт материал, цахим хуудастай танилцах,</li> <li>- Шалгах хуудас ашиглах</li> <li>- Тайлбар, мэдээлэл гаргуулах</li> <li>- Ярилцлага хийх,</li> <li>- Аудитын бусад горим, арга зүй</li> </ul>	
<b>Б. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 3.1.4, 3.1.5-д заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн эсэх</b>					
Б.1. Хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компаниуд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн эсэх	<ul style="list-style-type: none"> <li>- Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалт</li> <li>- Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- ТАБ-ын Санхүүгийн аудитад хамрагдсан Шилэн дансны тухай хуулийн 3.1.3-т заасан хуулийн этгээдийн жагсаалт</li> <li>- Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст бүртгэгдсэн Шилэн дансны тухай хуулийн 3.1.3-т заасан хуулийн этгээдийн жагсаалт</li> <li>- Шилэн дансны тухай хуулийн 3.1.3-т заасан хуулийн этгээдийн Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулсан мэдээлэл</li> <li>- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн мэдээ, тайлан</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- ЗГХЭГ-аас авсан байгууллагын жагсаалт</li> <li>- Аудитад хамрагдаж буй байгууллага</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Холбогдох баримт материал, цахим хуудастай танилцах,</li> <li>- Шалгах хуудас ашиглах</li> <li>- Тайлбар, мэдээлэл гаргуулах</li> <li>- Ярилцлага хийх,</li> <li>- Аудитын бусад горим, арга зүй</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Баталгаажуулалт хийх</li> <li>- Батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон төлөвлөсөн горимын дагуу нотлох зүйлд үндэслэн санал, дүгнэлт боловсруулах</li> </ul>
Б.2. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн эсэх	<ul style="list-style-type: none"> <li>- Шилэн дансны тухай хуулийн 6.9 дэх заалт</li> <li>- Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам</li> <li>- Концессын тухай хууль</li> <li>- Концессын зүйлийг батлах тухай Засгийн газрын тогтоол</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>2017-2018 оны төсвийн тухай хуулийн хөрөнгө оруулалтын жагсаалт</li> <li>- Сангийн яамны хөрөнгө оруулалтын газрын хөрөнгө оруулалтын арга хэмжээний эрх нээсэн байгууллагуудын жагсаалт</li> <li>- Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст бүртгэгдсэн улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил,</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>-Аудитад хамрагдах байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтан</li> <li>-Сангийн яам</li> <li>-Аудит хамрагдаж буй байгууллагын</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Холбогдох баримт материалтай танилцах,</li> <li>- Шалгах хуудас ашиглах,</li> <li>- Судалгаа хийх,</li> <li>- Тайлбар мэдээ гаргуулах,</li> <li>- Ярилцлага хийх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>-Нэгтгэн дүгнэх аргыг ашиглах,</li> <li>-Шинжилгээ хийх,</li> <li>-Баталгаажуулалт хийх</li> <li>- Батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон төлөвлөсөн</li> </ul>

СУДАЛГААНЫ АСУУЛТ (Бид юу мэдэхийг хүсэж байна вэ?)	ШАЛГУУР (Бид ямар стандарттай харьцуулж байгаа вэ?)	ШААРДЛАГАТАЙ НОТЛОХ ЗҮЙЛ (Ямар нотлох зүйл асуултад хариулах вэ?)	НОТЛОХ ЗҮЙЛИЙН ЭХ СУРВАЛЖ (Бид нотлох зүйлийг хэнээс олж авах вэ?)	МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ АРГА ЗҮЙ (Бид нотлох зүйлийг хэрхэн олж авах вэ?)	МЭДЭЭЛЛИЙГ ШИНЖЛЭХ АРГА ЗҮЙ (Олж авсны дараа бид юу хийх вэ?)
<p>Б.3. Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгчид шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн эсэх</p>	<p>- Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9 дахь заалт - Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам</p>	<p>үйлчилгээ, гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж байгууллага - Төрийн байгууллагуудаас ТББ болон ААНБ-тай байгуулсан үйлчилгээ үзүүлэх гэрээ - Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт бүртгэлтэй Шилэн дансны тухай хуулийн 3.1.3-т заасан хуулийн этгээдийн жагсаалт Засгийн газрын тогтоол - Сайдын тушаал - Удирдлагын тушаал, шийдвэр, - Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны мэдээлэл - Байгууллагын цахим хуудасны мэдээлэл - Хяналт-мониторингийн ажлын тайлан, баримт - Холбоотой талуудын тайлбар - Аудитын багийн гишүүдийн шаардлага хангасан тайлан - Харилцах дансны хуулга, - Санхүүгийн анхан шатны баримт - Санхүүжилт хийгдсэн баримтууд - Бусад шаардлагатай санхүүгийн баримтууд - Хэрэглэгч, иргэдийн санал</p>	<p>дотоод аудитын нэгж - Сангийн яамны Төрийн сангийн газар, Хөрөнгө оруулалтын газар, Нягтлан бодох бүртгэлийн газар - Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар</p>	<p>- Харьцуулсан судалгаа хийх, - Аудитын бусад горим, арга зүй</p>	<p>горимын дагуу нотлох зүйлд үндэслэн санал, дүгнэлт боловсруулах</p>
<p><b>В. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд холбогдох хяналтыг хэрэгжүүлж, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг биелүүлсэн эсэх</b></p>					
<p>В.1. Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2 дахь хэсэгт заасан байгууллага, албан тушаалтнууд холбогдох хяналтыг хэрэгжүүлсэн эсэх</p>	<p>- Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дахь заалт</p>	<p>- Бүх шатны ИНХ болон ИТХ-ын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьсан тухай ажлын тайлан, мэдээ, холбогдох ажлын баримт</p>	<p>- Бүх шатны ИНХ болон ИТХ - Шалгагдагч байгууллага</p>	<p>- Холбогдох баримт материалтай танилцах, - Шалгах хуудас ашиглах, - Судалгаа хийх, - Тайлбар мэдээ гаргуулах, - Ярилцлага хийх</p>	<p>-Нэгтгэн дүгнэх аргыг ашиглах, -Шинжилгээ хийх, -Баталгаажуулалт хийх</p>
<p>В.2. Хуулийн 3.1.3, 3.1.4, 3.1.5-д заасан байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд төсвийн ерөнхийлөн захирагчид хяналтыг хэрэгжүүлсэн эсэх</p>	<p>-Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь заалт</p>	<p>- Шалгагдагч байгууллагын харьяалах Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын нэгжийн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд дотоод хяналт хэрэгжүүлсэн талаарх тайлан, мэдээ, ажлын баримт</p>	<p>- Шалгагдагч байгууллагын харьяалах Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын нэгж - Шалгагдагч байгууллага</p>	<p>- Судалгаа хийх, - Тайлбар мэдээ гаргуулах, - Ярилцлага хийх - Харьцуулсан судалгаа хийх,</p>	<p>Батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон төлөвлөсөн горимын дагуу нотлох зүйлд үндэслэн санал, дүгнэлт боловсруулах</p>


СУДАЛГААНЫ АСУУЛТ (Бид юу мэдэхийг хүсэж байна вэ?)	ШАЛГУУР (Бид ямар стандарттай харьцуулж байгаа вэ?)	ШААРДЛАГАТАЙ НОТЛОХ ЗҮЙЛ (Ямар нотлох зүйл асуултад хариулах вэ?)	НОТЛОХ ЗҮЙЛИЙН ЭХ СУРВАЛЖ (Бид нотлох зүйлийг хэнээс олж авах вэ?)	МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ АРГА ЗҮЙ (Бид нотлох зүйлийг хэрхэн олж авах вэ?)	МЭДЭЭЛЛИЙГ ШИНЖЛЭХ АРГА ЗҮЙ (Олж авсны дараа бид юу хийх вэ?)
В.3. Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулсан мэдээлэлтэй иргэд олон нийт танилцаж, мэдээлэл нь ойлгомжтой, ач холбогдолтой байгаа эсэх	-Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалт	- Байгууллага, албан тушаалтны ажлыг дүгнэнсэн болон дээд шатны байгууллагаас хяналт шалгалт хийсэн ажлын тайлан, мэдээ, ажлын баримт	- Шалгагдагч байгууллага, албан тушаалтан - Шалгагдагч байгууллагын дээд шатны байгууллага	- Аудитын бусад горим, арга зүй	
В.4. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлсэн эсэх	-Шилэн дансны тухай хуулийн 9 дүгээр зүйл  -Өмнөх аудитын зөвлөмж	- Иргэдээс ирүүлсэн гомдол, мэдээлэл, хүсэлт - Иргэн, хуулийн этгээдээс Шилэн дансны тухай хуулийн 9.3-т заасны дагуу Захиргааны хэргийн шүүхэд гаргасан гомдол	- Төрийн аудитын байгууллага - Захиргааны хэргийн шүүхүүд - Иргэд		

Хянасан: НАГ-ын захирал бөгөөд тэргүүлэх аудитор

НАГ-ын аудитын менежер

Боловсруулсан: НАГ-ын ахлах аудитор

НАГ-ын аудитор



С.Энхбаатар

Х.Болдбаатар

Д.Отгонбаяр

С.Сугармаа

Ц.Цэрэннамжил